

Шүгэл үлээх системийн
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 03 сар




Агуулга

- Шүгэл үлээх системийн тайлан
- Баримт бичгийн шинэчлэлт
- Ёс зүйн хорооны бүтэц, бүрэлдэхүүн
- Сургалт, идэвхжүүлэлт

Шүгэл үлээх системийн тайлан

2024 онд ирсэн зөрчил, мэдээллийн шийдвэрлэгдсэн байдал



Шүгэл үлээх сувгаар 2022.11 сараас 2024.12 сарын хооронд 127 мэдээлэл ирсэн байгаагаас санал хүсэлт болон андуурч ирсэн мэдээлэл зэргийг хасаж, аливаа хэлбэрээр шийдвэр, зөвлөмж гарсан мэдээллийн тоо нь 86 хувьтай байна



Нийт ирсэн мэдээллийн 20 хувийг санал, хүсэлт эзэлж байна



78
2022 - 2023

49
2024

127
Нийт

Шүгэл үлээх системийн тайлан

2024 оны 01-12 сарын хугацаанд Шүгэл үлээх сувгаар ирсэн мэдээллийг эх сурвалж болон зөрчлийн төрөл, шийдвэрлэгдсэн байдлаар ангилбал

	Төрөл	Тоо	Хэрхэн шийдвэрлэсэн
Шүгэл үлээх сувгаар 34; Утсаар-10; Бусад сувгаар-5	Харилцааны зөрчил	18	13-Холбогдох газар, нэгж болон ажилтанд зөвлөмж хүргүүлсэн
			2-Нотлогдоогүй эсвэл нотлох боломжгүй тул хүлээн авч шийдвэрлэхээс татгалзсан
			3-Холбогдох газар, нэгжийн удирдлагад мэдээлэл, зөвлөмж өгч шилжүүлсэн.
	Хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөрчил	6	4-Зөвлөмж, үүрэг даалгавар хүргэгдсэн.
			1-Нотлогдоогүй эсвэл нотлох боломжгүй тул хүлээн авч шийдвэрлэхээс татгалзсан
			1-Холбогдох газар, нэгжид мэдээлэл шилжүүлэн шийдвэрлүүлэв
	Санал хүсэлт	10	8-Холбогдох газар, нэгжид мэдээлэл шилжүүлэн шийдвэрлүүлэв
			2-Холбогдох газар, нэгж болон ажилтанд зөвлөмж хүргүүлсэн
	Дотоод дүрэм, журам зөрчсөнтэй холбоотой зөрчил	3	Холбогдох газар, нэгж болон ажилтанд зөвлөмж хүргүүлсэн
	Шаардлага хангахгүй	3	Хааж шийдвэрлэсэн
	Ёс зүйн кодтой холбоотой зөрчил	2	Холбогдох газар, нэгж болон ажилтанд зөвлөмж хүргүүлсэн
	Мөнгө, бараа материал, бусад хөрөнгийн зүй бус ашиглалттай холбоотой зөрчил	1	Холбогдох газар, нэгжид шийдвэр хүргүүлсэн
	Ялгаварлан гадуурхахтай холбоотой зөрчил	2	Холбогдох газар, нэгжид шийдвэр хүргүүлсэн
Эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой зөрчил	1	Холбогдох газар, нэгжид мэдээлэл шилжүүлэн шийдвэрлүүлсэн	
Хувь хүний эрхэд халдсан	2	Холбогдох газар, нэгжид шийдвэр хүргүүлсэн	
Ажлын байрны дарамт, хавчлагатай холбоотой зөрчил	1	Холбогдох газар, нэгжид шийдвэр хүргүүлсэн	
	Нийт	49	

Шийдвэрлэсэн байдал		Тоо
НДХ-ны зөвлөмж, ажил сайжруулах үүрэг даалгавар		3
Ёс зүйн хорооны	Зөвлөмж	8
	Шийдвэр	4
Комплайнсын газрын	Зөвлөмж	4
Нийт		19

“Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам”-ын шинэчлэлт

Зорилго:

- Говь ХК-ийн үйл ажиллагааны ёс зүйн доголдлыг эрт үед нь илрүүлэх, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажилтны байгууллагадаа итгэх итгэлийг бэхжүүлж, байгууллагын тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой

Журамд орсон гол өөрчлөлтүүд:

- Зөрчил мэдээллийн төрлийг 16 байснаас 26 төрөл болгон нэмэгдүүлж ангиллыг нарийвчлан тодорхойлов.
- Мэдээлэл шийдвэрлэх хугацааг 60 байсныг 30 хоног болгон хуулийн нийцлийг хангуулав.
- Оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг шинэчлэн тодорхойлов.
- Мэдээлэл шийдвэрлэх хугацааг богиносгож, мэдээллийн хамрах хүрээ, үр дагавар, Ёс зүйн код болон холбогдох журмын хэдэн заалт зөрчсөн эсэх зэргээс хамаарч зэрэглэл тогтоов.

1

ЗЭРЭГЛЭЛ

Комплайнсын газар

Зөрчил, үл тохирлоос шалтгаалан Комплайнсын газраас шийдвэрлэх боломжтой байх

2

ЗЭРЭГЛЭЛ

Ёс зүйн хороо

Зөрчил, үл тохирлоос шалтгаалан Ёс зүйн хороо шийдвэрлэх боломжтой байх

3

ЗЭРЭГЛЭЛ

НДХ & ТУЗ

Нэр дэвшүүлэх хороо болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байх

“Ёс зүйн кодын хэрэгжилтийг зохицуулах журам”-ын шинэчлэлт

Зорилго:

- “Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам”-ын дагуу хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино

Журамд орсон гол өөрчлөлтүүд:

- Гишүүдийн тоог 13 байснаас 7 болгон цөөлөв. Ингэснээр гишүүдийн хариуцлага нэмэгдэж, оролцоо сайжрах нөхцөл бүрдэв.
- Ёс зүйн хорооны гишүүдийн 1/3-ээс доошгүй хувийг өмнөх жил Ёс зүйн хороонд ажиллаж байсан гишүүдээс сонгож үргэлжлүүлэн ажилладаг байхаар шинэчлэн залгамж халааг алдагдуулахгүй байх, мэдлэг туршлага дамжигдан үлдэх нөхцөл бүрдэв.
- Үүнтэй уялдуулан гишүүд сонгох зарчмыг шинэчлэн тодорхойлов.

Сонгон шалгаруулах зарчим

№	Улиран ажиллах гишүүдийг сонгох зарчим	Бусад гишүүд сонгох зарчим
1	Ёс зүйтэй байдал;	Байгууллагад нэг болон түүнээс дээш жил ажилласан;
2	Ажилласан хугацааны идэвх, оролцоо;	Ёс зүйтэй байдал;
3	Шийдвэр гаргах байдал;	Шударга ёсыг эрхэмлэн ажиллах зан чанараар хамт олондоо нэр хүндтэй;
4	Өөрийнх нь санал;	Ёс зүйн мэдрэмжтэй шийдвэр гаргадаг үлгэр жишээ ажилтныг дэвшүүлнэ
5	Бусад гишүүдийн санал;	
Сонгон шалгаруулах хугацаа		
Өмнөх		Одоо
12 сар тутам		18 сар тутам

Ёс зүйн хорооны бүтэц, бүрэлдэхүүн



С. Баттулга
Ёс зүйн хорооны гишүүн
ГБГ-Дижитал маркетер



Н.Бишгарав
Ёс зүйн хорооны гишүүн
ДХГ-Сүлжмэлийн программист
инженер



Г. Мөнхбилэг
Ёс зүйн хорооны дарга
ДБГ-ХЦНЗ Албаны дарга



Д. Идэртөгс
Ёс зүйн хорооны гишүүн
КГ-ЧХ Албаны дарга



Ц. Болормаа
Ёс зүйн хорооны гишүүн
НҮ-ЧТАлбаны дарга



Б. Барсолд
Ёс зүйн хорооны гишүүн
МТГ-Модуль менежер



Г. Ган-Эрдэнэ
Ёс зүйн хорооны нарийн бичгийн дарга
КГ-Комплайнсын ахлах менежер



Д. Мөнхбаатар
Ёс зүйн хорооны гишүүн
ҮҮГ-Агааржуулалтын инженер

Сургалт



“Аксиом Инк” ХХК-тай хамтран дунд түвшний удирдлагуудад зориулсан “Ажлын байрны ёс зүй ба Шүгэл үлээх системийн ач холбогдол” таниулах сургалт авав.



“Корпорейт Комплаенс Менежмент” ХХК-аас авсан зөвлөх үйлчилгээний хүрээнд “Ажлын байрны ёс зүй” сургалтад 145 ажилтныг хамруулав.



Дотоод хяналтын хүрээнд Хэнтий салбар нэгжийн ажилтнуудад “Ажлын байрны ёс зүй” сургалт оров.

Сургалт

Ёс зүйн хорооны гишүүд,
Комплайнсын газар болон бусад
газар нэгж, МЗ түвшний удирдлагууд




Сургалтын тоо **10**

Сургалтад хамрагдсан
ажилтнуудын тоо **268**

Гадны сургалт

Үйлдвэр удирдлагын газрын 5
үйлдвэр болон Хэнтий салбар
нэгжийн ажилтнууд



Сургалтын тоо **6**

Сургалтад хамрагдсан
ажилтнуудын тоо **766**

Дотоодын сургалт

Сургалт, идэвхжүүлэлт

Идэвхжүүлэлт

“Ёс зүйн хороо”-ноос нийт баялаг бүтээгч хамтран ажиллагсад, журмын нөхөд дөө урам өгөх, өдөр тутмын ажил үүрэгтээ Үнэт зүйлсээ шингээн хэвшүүлэх, нэгдсэн соёлыг дэлгэрүүлэх зорилготой “Ёс зүйн өдөрлөг”-ийг амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Өдөрлөгийн үеэр:

- “Үнэт зүйлс”-ээ тунхаглаж, нэгдмэл чанараа бэхжүүлэв,
- Халуун аарц, амттан тараагдаж эрүүл мэндийн дархлааг дэмжив.





GOBI
ETHICS

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.